



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 12 сарын 27 өдөр

Дугаар А/250

Улаанбаатар хот

Газар эзэмших эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5.3 дахь заалт, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны А/40 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Шинээр газар эзэмших хүсэлт ирүүлсэн 1 (Нэг) иргэнд өвөлжөө, хаваржааны зориулалтаар газар эзэмших эрхийг олгож, хавсралтаар баталсугай.

2.Газар эзэмших эрх олгогдсон иргэнтэй гэрээ байгуулж, гэрчилгээ олгон, Улсын бүртгэлд бүртгэж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Газар зохион байгуулалтын алба (Ч.Магадсайхан)-нд даалгасугай.

3.Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж, газрыг зориулалтын дагуу зөв зохистой эзэмшихийг хавсралтад нэр заагдсан иргэнд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД



Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын  
2023 оны 12 сарын 27-ны өдрийн 123/2023 дугаар  
захирамжийн хавсралт

ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХ ОЛГОЖ БАЙГАА ИРГЭДИЙН НЭРИЙН ЖАГСААЛТ

№	Оноосон нэр	Регистрийн дугаар	Газрын				
			Байршил	Зориулалт	Хэмжээ (м2-аар)	Хугацаа (жилээр)	Эдэлбэрийн хэлбэр
1	Гүргэнжав Баатарчулуун	УБ50060519	2-р хороо				
			Хөдөө баруун	Өвөлжөө, хаваржаа	700	15	Эзэмших